

БАТЛАВ  
"ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗАР"  
-ЫН ДАРГА



### ИНТЕРНЭТ БОЛОН ӨГӨГДЛИЙН СУВАГ ТҮРЭЭСИЙН ГЭРЭЭ

Дугаар: ИҮГ18/12

2018 оны 12 дугаар сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас "Эс Ай Си Ти" ХХК (цаашид "Үйлчилгээ үзүүлэгч" гэх)-ийн захирал Э.Болдхүү, нөгөө талаас "Гадаадын иргэн, харьяатын газар" (цаашид "Үйлчлүүлэгч" гэх)-ийг төлөөлж нар Мэдээллийн технологийн хэлтсийн дарга Т.Бат-Эрдэнэ (цаашид хамтад нь ТАЛУУД гэх) дараах нөхцлийг хэлэлцэн тохиролцож, харилцан зөвшөөрснөөр энэхүү гэрээг байгуулав.

#### НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Энэхүү гэрээний зорилго нь үйлчилгээ үзүүлэгч нь үйлчлүүлэгчид интернэт болон сувгийн холболтын үйлчилгээг үзүүлэх, үйлчилгээ үзүүлсэний дагуу үйлчлүүлэгч төлбөрийг төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Гэрээний хүчинтэй хугацаа 2018 оны 12 дугаар сарын 20 -ны өдрөөс 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл байна. Гэрээний хугацаа дуусахад аль нэг талаас гэрээг цуцлах буюу дуусгавар болгох санал ирээгүй тохиолдолд цаашид дахин нэг жилээр сунгагдсанд тооцно.

#### ХОЁР. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 2.1. Интернэт болон өгөгдлийн сувгийн холболтын үйлчилгээний байнгын хэвийн ажиллагааг хангаж ажиллах үүрэг хүлээнэ.
- 2.2. Үйлчилгээ үзүүлэгч нь гэрээнд заасны дагуу үйлчилгээний төлбөрөө нэхэмжлэх, төлбөрөө төлөхийг шаардах эрхтэй.
- 2.3. Үйлчлүүлэгчийн буруутай үйл ажиллагаанаас болж үйлчилгээ тасалдах, тоног төхөөрөмж эвдрэх зэргийг үйлчилгээ үзүүлэгч хариуцахгүй.
- 2.4. Сүлжээнд гэнэтийн осол, гэмтэл гарсан үед үйлчлүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр сүлжээг таслан засвар үйлчилгээг хийх эрхтэй.
- 2.5. Гэрээнд заасан нөхцлийн дагуу үйлчлүүлэгчээс ирсэн сандал гомдлыг хүлээн авч түргэн шуурхай шийдвэрлэнэ.
- 2.6. Төлөвлөгөөт болон техникийн үйлчилгээг жилд 4-өөс доошгүй удаа 1 цагаас ихгүй хугацаанд хийнэ. Ажлыг гүйцэтгэхэд 48 цагийн өмнө үйлчлүүлэгчид мэдэгдэж, ажлын бус цагаар явуулах ба энэ хугацаа Үйлчилгээ тасалдсанд тооцогдохгүй.
- 2.7. Гэрээг хэрэгжүүлэх явцад гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлээс хамаарсан гэмтэл, саатлын хариуцлагыг хариуцахгүй.

#### ГУРАВ. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1. Гэрээнд заасан үйлчилгээний төрөл, нөхцлийн дагуу үйлчилгээгээр хангуулах эрхтэй.
- 3.2. Үйлчилгээ үзүүлэгчийг гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.
- 3.3. Үйлчилгээний талаар санал, гомдол гарсан үед үйлчилгээ үзүүлэгчид мэдэгдэж шийдвэрлүүлэх эрхтэй.
- 3.4. Үйлчилгээний төлбөрийг заасан хугацаанд төлөх үүрэг хүлээнэ.
- 3.5. Өөрийн компьютер, гар утас зэрэг сүлжээнд холбогдон ажиллаж байгаа төхөөрөмжүүдийн аюулгүй байдал, мэдээний аюулгүй байдал зэргийг бүрэн хариуцна.
- 3.6. Сүлжээнд гэмтэл, саатал гарсан тохиолдолд энэ тухай нон даруй үйлчилгээ үзүүлэгчийн 99000076, 99072314 утсанд мэдэгдэнэ.

### ДӨРӨВ.ТӨЛБӨР ТООЦОО

- 4.1 Үйлчлүүлэгч нь энэхүү гэрээний хавсралтад заасан нэг сарын үйлчилгээний төлбөрийг үйлчилгээ үзүүлэгчийн Godomt банкны 1410006739 (төгрөгийн) дансанд нэхэмжлэхийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор төлнө.
- 4.2 Үйлчилгээ үзүүлэгч нь үйлчлүүлэгчээс төлбөр хүлээн авмагц НӨАТ-ын хуулийн 4.1.14 заалтын дагуу шаардлага хангасан төлбөрийн баримтыг **ТҮРЭСЛЭГЧИЙН** altantulga.sh@immigration.gov.mn хаяг руу илгээх ба НӨАТ-ын хуулийн 17.3.4 заалтын дагуу холбогдох борлуулалтын мэдээллээ 7 хоногт багтаан татварын нэгдсэн системд илгээнэ.
- 4.3 Энэхүү гэрээг байгуулсан үйлчлүүлэгч үйлчилгээг ашиглаж эхэлсэн өдрөөс үйлчилгээний хугацааг тооцно.
- 4.4 Үйлчлүүлэгч үйлчилгээг анх удаа авахад анхны холболтын хурцаж 276,000 төгрөгийг чиглээ тус бүрт нэг удаа төлнө.
- 4.5 Үйлчлүүлэгч нь хугацаандаа төлбөрөө төлөөгүй тохиолдолд хэтэрсэн хоног тутамд 0,1%-ийн алданги төлнө.
- 4.6 Төлбөрийг тооцооны сараар авах ба энэ хугацаа нь хуанлийн сартай тэнцүү байна.
- 4.7 Үйлчилгээний гэрээ болон захиалгыг дуусгавар болгон цуцлах тохиолдолд анхны холболтын хурцаж буцаан төлөгдөхгүй.

### ТАВ. ГЭРЭЭГ ӨӨРЧЛӨХ, ЦУЦЛАХ

- 5.1 Үйлчлүүлэгч нь үйлчилгээний төлбөрөө хугацаанд нь төлөөгүй, гэрээгээр заасан үүргүүдээ биелүүлээгүй тохиолдолд үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээг шууд зогсооно.
- 5.2 ТАЛУУД гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд санаачлагч ТАЛ ажлын 10 хоногийн өмнө албан бичгээр мэдэгдэж өөрчлөлт оруулна.
- 5.3 Энэхүү өөрчлөлт нь ТАЛУУД гарын үсэг зурснаар баталгаажна.
- 5.4 Үйлчлүүлэгч гэрээгээ цуцлах болсон бол үйлчилгээ үзүүлэгчид сараас доошгүй хугацааны өмнө албан бичгээр мэдэгдэнэ.
- 5.5 Гэрээг цуцласан өдөр хүртлэх үйлчилгээний төлбөрийг үйлчлүүлэгч төлж барагдуулсан байна.

### ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ

- 6.1 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж баталгаажуулсанаас эхлэн гэрээг цуцлах хүртэл хүчин төгөлдөр байна.
- 6.2 Гэрээг 2 хувь үйлдэж талууд тус бүр нэг, нэг хувийг хадгалах ба гэрээний хувь тус бүр хууль зүйн хувьд ажил хүчинтэй байна.
- 6.3 Энэхүү гэрээтэй холбогдон үүсч болох маргаан, санал зөрөлдөөнийг талууд харилцан зөвшилцөж журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд шийдвэрлэж чадахгүй бол шүүхээр маргааныг шийдвэрлүүлнэ.
- 6.4 Энэ гэрээнд заагаагүй аливаа асуудлыг Монгол улсад дагаж мөрдөж байгаа хуулиудаар зохицуулна.

### ДОЛОО.ТАЛУУДЫН АЛБАН ЁСНЫ ХАЯГ, БУСАД ӨГӨГДӨЛ

Хаяг: Улаанбаатар хот, Хан Уул дүүрэг, 15-р хороо, 7 байр, 124 тоот, "Эс ай си ти" ХХК байр

Утас: +976-99000076, +976-99072314  
Э-шуудан: Boldoo\_0714@yahoo.com  
Веб хуудас: SICTLLC.mn

Регистрийн дугаар: 360866  
Улсын бүртгэлийн дугаар: 9011355085

Хаяг: Улаанбаатар хот Хан-Уул дүүрэг 10-о хороо ГИХГ-ын байр

Утас: 7013-3478  
Факс: 7013-3458  
Э-шуудан: altantulga.sh@immigration.gov.mn

Веб хуудас: immigration.gov.mn  
Регистрийн дугаар: 2712253  
Улсын бүртгэлийн дугаар:

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

Талууд энэхүү гэрээнд заасан бүхий л нөхцөл, заалтуудыг хүүлэн зөвшөөрч байгаагаа нотлон доор гарын үсэг зурж, баталгаажуулав.

**"Үйлчилгээ үзүүлэгч"-ийг төлөөлж:**

2024.07.07 Э.Болдхүү  
Ерөнхий захирал



**"Үйлчлүүлэгч"-ийг төлөөлж:**

Мэдээллийн технологийн хэлтсийн дарга  
Т.Бат-Эрдэнэ

A handwritten signature in black ink, appearing to be "Т.Бат-Эрдэнэ".